

6

**ОЛБОРЛОХ САЛБАРЫН НИЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ**

Р.Бадамханд

Ашигт малтмал олборлох үйл ажиллагааны онцлог, сүүлийн жилүүдэд энэ салбарт гарч байгаа техник технологийн дэвшил, бүс нутаг байршлийн өөрчлөлт түүний дэлхийн байгаль орчин ба эдийн засагт үзүүлж буй нөлөө, даяаршлалд гүйцэтгэх үүрэг зэргээс шалтгаалан өнгөрсөн зууны ерээд оноос уул уурхайн салбарын нягтлан бодох бүртгэлийг боловсронгуй болгох асуудал олон улсын хэмжээнд өргөнөөр тавигдаж эхэлсэн билээ. Ашигт малтмалын хайгуулын болоод орд газрын үнэлгээний зардлыг бүртгэхдээ тухайн аж ахуйн нэгж зөвхөн “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн үнэлэмж ба алдааны өөрчлөлт” гэсэн НББОУС 8 –ыг баримтлан өөр өөрийн бүртгэлийн бодлогоо боловсруулах хэрэгтэй байсан нь их хэмжээгээр гардаг хайгуулын болоод үнэлгээний ажлын зардлыг өөр өөр байгууллагын төвшинд зөрүүтэйгээр бүртгэж тайлагнах нөхцөлийг бий болгон уг мэдээллийг харьцуулан дүн шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж байв.

Иймээс 1998 онд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо /хуучин нэрээр/ -ноос “Олборлох салбарын асуудал” нэртэй хэлэлцүүлгийн баримт бичиг гаргасан бөгөөд үүнд дараах нилээд маргаантай байдаг асуудлыг шийдвэрлэх зорилт тавьж байв. Үүнд:

- Капиталжуулсан зардалд хорогдол /элэгдүүлэг/ тооцох аргыг боловсронгуй болгох

- Бүртгэлийн объект, үнэлгээ ба мэдээллийн бүрэн байдалд ашигт малтмалын хэмжээ, баяжилтын нөлөөллийн түвшинг тогтоох

- Ашигт малтмалын нөөцийн үнэлгээ гэх мэт.

2004 оны сүүлч хүртэл хугацаанд энэхүү стандарттай холбоотой 55 санал хүлээн авч хэлэлцүүлсний дараа “Ашигт малтмалын хайгуул ба үнэлгээ” СТОУС 6-г батлан гаргасан нь 2006 оны 1-р сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна. Уг стандартыг батлах явцад олон асуудал дээр зөвлөлийн гишүүд шүүмжлэлтэй хандаж санал зөрж байсан бөгөөд нийт 14 гишүүний 4 нь батлахаас татгалзсан байдаг. Энэ бүхэн нь олборлох салбарын хайгуул судалгааны болоод бусад үе шатны нягтлан

бодох бүртгэлийн асуудал цаашид ч боловсронгуй болох шаардлагатай байгааг тод харуулж байна.

27 зүйл бүхий “Ашигт малтмалын хайгуул ба үнэлгээ” СТОУС -6 нь нягтлан бодох бүртгэл, тайлагналд баримтлах үндсэн ойлголт болоод зарчмуудыг нилээд өргөн хүрээнд буюу ерөнхий байдлаар тодруулж өгсөн. Үүнд:

- Орд газрын ашигт малтмалын нөөцийг ашиглах боломжтой гэдгийг техник- эдийн засгийн урьдчилсан судалгаагаар тогтоох хүртэл гарч байгаа зардлыг ашигт малтмалын хайгуул, үнэлгээний үеийн зардал гэж үзнэ. Харин хайгуулын эрх авахаас өмнө гарч байсан зардал үүнд хамаарахгүй.

- Ашигт малтмалын хайгуул, үнэлгээний хөрөнгийг уг үйл ажиллагааг эрхлэж буй аж ахуйн нэгжийн бүртгэлийн бодлогод нийцүүлэн ирээдүй цагийн зардалд /капиталжуулах/ эсвэл тайлант үеийн зардалд бүртгэх бөгөөд энэ нь түүхэн өртөгт суурилна.

- Хайгуул, үнэлгээний хөрөнгийн өртөгт дараахи үйл ажиллагаатай холбоо бүхий зардлыг хамааруулна:

а. Хайгуулын лиценз, зөвшөөрөл

б. Торограф, геологи, геохими, геофизикийн судалгаа

в. Хайгуулын өрөмдлөг

г. Цооног гаргалт

д. Сорьцлолт

е. Орд газрын техник- эдийн засгийн урьдчилсан үнэлгээ гэх мэт.

- Хайгуул, үнэлгээний зардлыг хөрөнгийн бие даасан бүлэг болгон авч үзнэ.

- Хайгуул, үнэлгээний хөрөнгийг биет / тоног төхөөрөмж, өрмийн цооног гэх мэт/ ба биет бус /хайгуулын лиценз, үнэлгээний тайлан гэх мэт/ гэж ангилах бөгөөд зарим биет хөрөнгө биет бус хөрөнгийг бий болгоход зориулагддаг боловч бүртгэлд биет хөрөнгөөр тусгана.

- Хайгуул, үнэлгээний хөрөнгө зөвхөн тухайн орд газрын техник - эдийн засгийн урьдчилсан үнэлгээ хийгдэж дуусах хүртэлх үед бүртгэгдэнэ.

- Хайгуул, үнэлгээний хөрөнгийг аж ахуйн нэгж бүртгэлийн бодлогоо өөрчлөх, хайгуул, үнэлгээний хөрөнгийн өртөг нөхөн төлөгдөх магадлал буурах зэрэг шалтгаанаар алдагдал болгоно. Ийнхүү алдагдал болгож буй хайгуул, үнэлгээний хөрөнгө доорхи шалгууруудын ядаж аль нэгийг хангасан байх ёстой.

а. Хайгуулын лицензэд заагдсан тухайн орд газарт хийх хайгуулын зөвшөөрлийн хугацаа дуусч байгаа бөгөөд цаашид сунгагдахгүй нь тодорхой байх,

б. Тухайн орд газарт цаашид хийх хайгуулын зардлын санхүүжилт зогсох, төлөвлөх боломжгүй болох,

в. Хайгуул хийж буй орд газрын нөөц эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тодорхой болж хайгуулыг зогсоох,

г. Орд газрыг олборлох боломжтой боловч олборлолтоос хүлээгдэж буй үр ашиг эсвэл орд газрыг зарах үнэ нь хайгуулын зардлыг нөхөж хүрэлцэхгүй нь тодорхой болох гэх мэт.

- Аж ахуйн нэгж хайгуул, үнэлгээний хөрөнгийн үнэ цэнийн бууралт буюу алдагдлыг өөрийн харьяа салбар нэгжүүдэд хуваарилах талаар бүртгэлийн бодлогодоо тодорхой тусгах ёстой бөгөөд энэхүү нэгж нь сегментээс томгүй байна.

- Ашигт малтмалын хайгуул, үнэлгээ хийгч байгууллага энэ төрлийн зардал, хөрөнгөө бүртгэх бодлого болон хөрөнгө оруулалтынхаа талаар санхүүгийн тайландаа тодруулга хийх ёстой гэх зэрэг болно.

Энэхүү стандартыг ашигт малтмалыг ашиглахтай холбоотой бүтээн босголтын үеийн зардал мөн одоо ажиллаж буй уурхайн хувьд нөөц газартаа үргэлжлүүлэн хийх хайгуул судалгааны ажлын зардлыг бүртгэхэд баримтлахгүй юм. Иймд олборлох салбарын нягтлан бодох бүртгэлийн асуудлыг бүхэлд нь авч үзэхийн тулд үйл ажиллагааны үе шатыг бүртгэлийн зориулалтаар ангилан түүний зардлыг зааглах асуудал чухал болж байна. Тухайлбал,

1. Хайгуул судалгааны эрх авахын өмнөх үе / урьдчилан хийж байсан судалгаа, зөвлөгөөтэй холбоотой зардлуудыг тусгаарлах зорилгоор/
2. Хайгуул судалгааны үе / СТОУС 6-д заасан зардлуудыг тусгайлан бүртгэх зорилгоор/
3. Бүтээн босголтын үе / уурхай болон дэд бүтцийн өртгийг тооцох зорилгоор/
4. Олборлолтын үе /бүтээгдхүүний өртгийг тооцох/ гэх мэт.

Түүнчлэн СТОУС –д тулгуурлан бүртгэлийн бодлого боловсруулан аль шатны ямар ямар зардлыг хэрхэн капиталжуулах болоод тайлант үеийн зардалд тооцож байхыг хуримтлал хэрэгжилтийн /аккруэль/ зарчмын дагуу тодорхойлох шаардлагатай байгаа билээ. Хайгуулын зардлыг капиталжуулахдаа нийт капиталжсан зардал ирээдүйн олох ашгиас хэтэрч болохгүй нөхцөлийг харгалзан хайгуул судалгааны шат хэтэрхий сунжрах, хөрөнгө оруулалтын ноцтой шалтгаан гарах зэрэгт зардлыг капиталжуулах эсэх талаар удирдлага шийдвэр гаргах бөгөөд хэрэв нийт капиталжсан зардлын дүн ирээдүйд олох ашгиас давбал капиталжуулалтыг зогсоодог олон улсын практикийг стандартын заалттай уялдуулан авч үзэх нь зүйтэй. Олборлолт эхлэсний дараа үргэлжлэн хийгдэж буй хайгуул, судалгаа хөгжлийн зардал нь ирээдүйд орлого оруулах буюу үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх магадлалтай бол түүнийг капиталжуулна харин хайгуул судалгааны ажлын үр дүн тодорхой бус бол зардлыг хуримтлуулах шаардлагагүй. Уурхайн компаниуд хайгуул болон үйлдвэрлэлийн үе шатандаа нягтлан бодох бүртгэлийн өөр арга, бодлого баримтлаж болох бөгөөд капиталжуулах зардлын хувьд ирээдүйн орлого ашиг нь аль болох баталгаатай байх зарчмыг баримтладаг.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тодорхойлсон байх зүйлийн нэг бол олон улсын практикт өргөн хэрэглэдэг хайгуулын зардлыг бүртгэх

аргын хэрэглээ сонголтын зарчим юм. Олон улсын практикт дараах 3 аргыг хэрэглэдэг. Үүнд:

- “Сонирхолын – хэсэг” /Area-of-interest method/
- “Амжилттай – нээлт” /Successful-efforts method/
- “Бүрэн - өртөг” / Full –cost method/

Дээрхи аргуудаас сонирхолын - бүс аргыг илүү түгээмэл хэрэглэдэг бөгөөд зардлын төвүүдийг хайгуулын лиценз тус бүрээр үүсгэн тэдгээрт хуваарилагдах хайгуулын ерөнхий зардлыг хайгуулын талбайн хэмжээ эсвэл үндсэн зардал болох өрөмдлөгийн ажлын хэмжээнд харьцуулан авч үзэж болно.

Тухайн салбарын бүтээгдхүүний өртгийн бүтцэд байгаль орчныг нөхөн сэргээх зардал болон хайгуулын болон бүтээн байгуулалтын үеийн капиталжуулсан зардлын хуваарилалттай холбоотой онцлог байдаг. Өөрөөр хэлбэл өртгийн зохих хувийг энэ төрлийн зардлууд бий болгодог тул өртгийн тайлангийн хувьд энэхүү онцлог тусгагдах хэрэгтэй. Өртөг тооцох болон тайлагнах нэгдсэн стандарт байхгүй ч практикт сонгон хэрэглэх боломжтой олон арга горимууд байдаг. Жишээ нь, АНУ -д Алтны уурхайн институтээс боловсруулан гаргасан алтны өртгийг тайлагнах албан бус стандарт байдаг байна. Энэ нь гарцын нэгжийн өртгийг тодорхойлон харуулах бөгөөд ил болон далд аль ч уурхайд хэрэглэх боломжтой.

Алтны Институтын стандарт загвар

	I унцад ногдох
Уурхайн шууд зардал	x
Уурхайн судалгаа, хөгжлийн зардал хуваарилалт	x
Бусдаар гүйцэтгүүлсэн засвар, үйлчилгээ ба тээврийн зардал	x
Дайвар бүтээгдхүүн	x
Бусад	x

Мөнгөн зардлын дүн	x

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	x
Бусад татвар, хураамж	x

Мөнгөн өртгийн дүн	x

Элэгдэл	x
Хорогдол	x
Нөхөн сэргээх нөөц	x

Үйлдвэрлэлийн нийт өртөг	x

Олборлох салбарт хийх шинжилгээний асуудалд салбарын онцлогыг тусгасан харьцаануудыг олноор тодорхойлдог учир түүнд зориулсан мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт тусгаж байх шаардлагатай юм. Тухайлбал, олборлох салбарт үйл ажиллагаа

явуулж буй компанийн өртгийг /enterprise value/ доорхи томъёогоор тодорхойлдог.

$$EV = \frac{FCFF}{(1+WACC)^n}$$

FCFF / Free cash flow to firm/ - мөнгөн хөрөнгийн чөлөөт орох урсгал буюу хөрөнгө оруулалтаар авч буй мөнгөн хөрөнгө

WACC / weighted average cost of capital / - бүх төрлийн урт хугацаат хөрөнгө оруулалтын жилийн дундаж хэмжээ

n- Үнэлгээнд хамрагдаж буй хугацаа

Дээрхи аргачлалд зориулсан хөрөнгө оруулалтын тайланг гаргах дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөх гэх мэт.

Дүгнэлт:

Монгол улсын эдийн засагт нөлөө бүхий байр суурийг эзэлдэг олборлох салбарыг цаашид ч гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах гол талбар болгон хөгжүүлэхээр төрөөс төлөвлөж байгаа өнөө үед уг салбарын үйл ажиллагаа ялангуяа энэ салбар дахь хөрөнгө оруулалтын нилээд хэсгийг эзлэх хайгуул судалгааны үеийн зардлын нягтлан бодох бүртгэлийг боловсронгуй болгоход чиглэсэн эхний алхам болох СТОУС 6 –н үйлчлэх хүрээ нарийн заагтайгаас гадна бүртгэлийн олон асуудал нээлттэй хэвээр байгаа билээ. Тухайлбал нь,

- капиталжуулах зардал ба нөөцийн хоорондын харьцаа, нөөц бүрэн тогтоогдоогүй байгаа үед баримтлах зарчим, нөөцийн үнэлгээ,
- капиталжуулсан зардлыг тайлагнах буюу балансад тусгах ангилал / биет хөрөнгө, биет бус хөрөнгө эсвэл хөрөнгө оруулалт/ ,
- хайгуулын үеийн ерөнхий удирдлагын зардлын хуваарилалт,
- капиталжуулсан зардлын хорогдуулалт,
- олборлолт эхлэсэн үеийн зардлын ангилал гэх мэт.

Иймд манай улсын бусад хууль тогтоомжуудтай уялдуулан олборлох салбарын нягтлан бодох бүртгэлийн заавар, цаашилбал бүртгэлийн үндэсний стандартыг боловсруулан гаргах зайлшгүй шаардлага бий болоод байна.